



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 6 сарын 22 өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2004-2005 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад +-суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нямжав овогтой Даваасүрэнг АНУ-ын Калифорнийн Улсын Их сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр, Нацагдорж овогтой Сэвжидийг АНУ-ын Калифорнийн Улсын Их сургуулийн магистрантурт эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

А.ЦАНЖИД